

ЗАРИМ ХАВСАРГА СУДАЛГААНЫ ЧАНАРТ ХИЙСЭН ТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭ

Б. Бат-Өлзий (Ph. D.)

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
bbatulzii04@gmail.com*

Хураангуй: Нийгмийн судалгааны олон ангилал, төрөл хэлбэр байдаг ба тэдгээрийн нэг чухал хэлбэр нь хавсарга судалгаа юм. Хавсарга судалгааны гол онцлог нь илүү практик шинжтэй асуудал буюу хувь хүн, бүлэг, олон нийт, байгууллага, орон нутаг, улс орны өмнө тулгамдаж буй асуудлуудыг нэн даруй, яаралтай судлан тодорхойлох зорилготой. Өгүүллийн хүрээнд Монголд хийгдэж буй зарим хавсарга судалгааг сонгон, тэдгээрийн гүйцэтгэл, чанарт тандалт шинжилгээ хийлээ. Тандалт шинжилгээний үр дүнгээс харвал манайд хийгдэж буй хавсарга судалгаанууд нь судалгааны аргазүй, аргачлалын наад захын шаардлага, хэм хэмжээг хангахгүй байгаа дүр зураг гарч байна. Тиймээс цаашид хавсарга судалгааны чанар, стандартыг тогтоох, түүнийг мөрдөх, хянах, үнэлэх хэм хэмжээ, соёлыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Түлхүүр үгс: Хавсарга судалгаа, судалгааны чанар, судалгааны стандарт

I. УДИРТГАЛ ХЭСЭГ

Нийгмийн шинжлэх ухааны судалгааг янз бүрийн шалгуураар төрөл, хэлбэрт ангилдаг. Юуны өмнө нийгмийн шинжлэх ухааны бүрэлдэхүүнд багтах бие даасан шинжлэх ухаанд харъяалагдаж, ангилагдана. Үүнд социологийн судалгаа, нийгмийн ажлын судалгаа, сэтгэл судлалын судалгаа, эдийн засгийн судалгаа, улс төр судлалын судалгаа, менежментийн судалгаа, маркетингийн судалгаа гэх мэт. Гэвч эдгээр нь бие биенээсээ эрс ялгаатай судалгаанууд биш бөгөөд судалгааны арга, арга зүй, аргачлал нь нийтлэг байдаг. Үндсэндээ тухайн шинжлэх ухаан юу судалдагаар буюу “судлах зүйл”-ээрээ л өөр хоорондоо ялгагддаг гэж хэлж болно. Тухайлбал социологи, нийгмийн ажил, маркетингийн судалгаа нь бүгдээрээ анкет, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, баримт бичиг судлах гэх мэт аргаар мэдээлэл цуглуулах бөгөөд мэдээлэл цуглуулах аргыг судалгаанд хэрэглэх арга зүй, аргачлал, үр дүнг боловсруулалт зэрэг нь адилхан. Тиймээс “нийгмийн судалгаа”, “нийгмийн судалгааны арга зүй”, “нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга, арга зүй” гэх мэт ерөнхий томъёолол сурах бичгүүдэд нийтлэг байх ба эдгээр нь бүхий л нийгмийн шинжлэх ухаануудын судалгааг багтаасан өргөн ойлголт юм. Энэхүү өгүүлэлдээ “нийгмийн ухааны судалгаа” гэсэн өргөн агуулгаар асуудлыг авч үзэж байгаа болно.

Түүнчлэн сурах бичгүүдэд нийгмийн шинжлэх ухааны судалгааг объект (судлагдахуун)-д хэмжилт хийх, мэдээлэл цуглуулах, боловсруулах

арга зүйн талаас нь *тоон судалгаа ба чанарын судалгаа*, танин мэдэхүйн түвшин ба мэдлэг бүтээх зорилгоор нь *хайгуул судалгаа, тодорхойлох судалгаа, тайлбар судалгаа*, мөн танин мэдэхүйн түвшин (мэдлэг бүтээх) болон мэдлэгийн хэрэглээгээр нь *академик судалгаа* (суурь судалгаа, цэвэр судалгаа гэж орчуулах нь бий) ба *хавсарга судалгаа* гэж ангилдаг.

Судалгааны эдгээр ангилал, төрөл хэлбэрүүд дотроос хавсарга судалгааг сонгож өгүүлэлээ бичиж байна. Өгүүллийн гол зорилго нь манай улсад хийгдэж буй зарим хавсарга судалгаанд анхдагч шинжилгээ хийх, тэдгээрийн чанарын түвшин ямар байна, судалгааны ажлын үе шат, дэс дараалал, дэг жаяг, арга зүй аргачлалаа хэрхэн баримталж, хэр зэрэг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа хийж байна вэ гэдэгт тандалт шинжилгээ хийх явдал юм.

II. ОНОЛ, АРГА ЗҮЙ ХЭСЭГ

Нийгмийн судалгааг бүтээж буй мэдлэг, танин мэдэхүйн түвшин, судалгааны зорилго, үр дүн, хэрэглээ, хэрэглэгч, үр дүнг ашиглах байдлаар нь академик судалгаа ба хавсарга судалгаа гэж ангилдаг талаар дээр өгүүлсэн. Академик судалгаа нь шинжлэх ухааны танин мэдэхүй, онол арга зүйн харьцангуй өндөр түвшинд хийгддэг судалгаа гэж хэлж болно. Энэ судалгааг онолын судалгаа, суурь судалгаа гэх мэтээр монгол хэлнээ хөрвүүлдэг. Академик судалгаа нь шинжлэх ухааны танин мэдэхүйн хэрэгцээг хангах зорилготой, нийгэм, хүмүүсийн харилцааны мөн чанарыг тайлбарласан онол, үзэл баримтлал, хандлагууд дээр тулгуурлаж, тэдгээрийг батлах, няцаах, шинэ мэдлэг, онол, аргачлал, аргазүйг боловсруулж байдаг. Энэ судалгааг эрдэмтэд, судлаачид, шинжлэх ухааны байгууллагууд, их сургуулиуд эрхлэн явуулдаг. Өөрөөр хэлбэл дурын хүний барьж аваад хийчихдэг судалгаа биш юм. Академик судалгааны үр дүнг хэрэглэгчид нь ч мөн л их сургуулиуд, багш нар, эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн ангийн оюутнууд байх бөгөөд эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, нэг сэдэвт бүтээл хэлбэрээр хэрэглэгчдээ хүрдэг. Судалгааны чанар, үр дүн нь эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, институт, их сургууль, эрдэмтэдийн хэлэлцүүлэгээр шүүгддэг. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй сэтгүүл, хэвлэлийн газарт хэвлэгдэж, олон эрдэмтэдийн хэлэлцүүлгээр орж, хэр олон судлаач эрдэмтэд ишлэл авч судалгаандаа ашигласанаар уг судалгааны чанарыг хэмждэг. Академик судалгааны бас нэг онцлог нь хүн төрөлхтөний болон нийгмийн суурь мөн чанарт илүүтэй анхаарал хандуулдаг. Энэ утгаараа уг судалгаа нь нийгмийн харилцааны өдөр тутмын тулгамдсан асуудалд бага анхаарч харин ирээдүйд чиглэсэн, урт хугацаанд үр дүнгээ өгөх онолын шинжтэй асуудалд түлхүү анхаарал хандуулдаг. Тиймээс академик судалгаанууд нь харьцангуй урт

хугацаад үргэлжилдэг. Академик судалгааны сэдвүүд нь судлаач, эрдэмтэдийн чөлөөт сонголт, сонирхол байхын сацуу улс орнуудын төр, засгийн газрууд нийгмийнхээ болон хүн төрөлхтөний ирээдүйн сайн сайхны төлөө бодлогоор дэмжин их сургууль, судалгааны байгууллагууд, судлаач, эрдэмтэддээ захиалга өгч, санхүүжүүлэн хийлгэдэг. Харин нийгэм, нийгмийн гишүүд, жирийн иргэд, аливаа байгууллагууд академик судалгааны үр дүнг шууд авч хэрэглэх нь бага бөгөөд тэдний амьдрал үйл ажиллагаанд шууд бус дам байдлаар, урт хугацаанд үр нөлөөгөө өгдөг.

Нийгмийн судалгааг зоостой зүйрлэвэл нэг тал академик судалгаа, нөгөө тал нь хавсарга судалгаа юм. Хавсарга судалгаа нь академик судалгааны бага анхаардаг асуудлыг сонирхон судалсанаар нийгмийн судалгааг бүрэн цогц болгодог гэж хэлж болно. Нийгмийн өдөр тутмын амьдралд тохиолддог бэрхшээлтэй асуудлыг цаг алдалгүй судлаж, шийдвэрлэх гарц гаргалгааны талаар мэдлэг бүтээж байдаг судалгаа бол хавсарга судалгаа юм. Нийгэм, хүмүүс, байгууллага, төр засаг, орон нутгийн засаг захиргааны өдөр тутмын амьдралд тохиолдож буй тулгамдсан асуудал нь цаг алдалгүй маш хурдан судлаж, танин мэдэж, хариу арга хэмжээ авч байхыг шаарддаг. Технологийн үсрэнгүй хөгжил, аливаа мэдээлэл тархах хурд зэргээс шалтгаалан энэ шаардлага улам бүр хурцаар тавигдсаар байна. Тиймээс хавсарга судалгаа нь энэ шаардлагын дагуу маш богино хугацаанд аливаа асуудлыг танин мэдэж, шийдвэрлэх арга зүй, зөвлөмжийг санал болгодог. Хавсарга судалгааны үр дүнг гол хэрэглэгч нь иргэд, бизнес эрхлэгчид, зөвлөгөө өгөгчид, оюутнууд, албан хаагчид, захиргааны ажилтнууд, бодлого боловсруулагчид, нийгмийн ажилтнууд зэрэг нийгмийн олонхи байх бөгөөд судалгааны мэдлэг, үр дүн, тайлан, санал зөвлөмж нь амьдралд хэрэгжүүлэхэд ойр дөхөм, энгийн ойлгомжтой, шууд ажил, бизнес, үйл ажиллагаандаа ашиглахуйц байхыг шаарддаг. Практик мэргэжлийн хүмүүс энэ судалгааны үр дүнг түлхүү ашигладаг. Хавсарга судалгааг судлаач, эрдэмтэдээс гадна судалгааны арга зүйг тодорхой хэмжээнд эзэмшсэн (их сургуульд судалгааны арга зүйн хичээл заалгасан) практик ажилтнууд өөрсдөө хийж үйл ажиллагаа, ажил бизнесдээ ашиглах нь нийтлэг байдаг. Мөн хавсарга судалгаагаар мэргэшсэн, энэ чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулдаг бизнесийн шинжтэй судалгааны төв, байгууллагууд цөөнгүй байх бөгөөд тэд төлбөртэйгээр төрийн байгууллага, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэдийн захиалгаар төрөл бүрийн хавсарга судалгаа явуулж, судалгааны үр дүнд тулгуурлан тайлан бичих, улмаар зөвлөгөө өгөх үйлчилгээ эрхэлдэг. Академик судалгаатай харьцуулахад хавсарга судалгаа нь онолын асуудалд бага анхаардаг ч энэ шинжээр нь түүнийг шинжлэх ухаанаас хол хөндий, онолын бус гэж дүгнэх нь алдаа болно. Харин ч хавсарга судалгаа нь судлагдахууныхаа онцлогт

тохирсон нийгмийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлал, арга зүйг ашиглан судалгаа шинжилгээгээ явуулах ба судалгааныхаа үр дүнг шинжлэх ухаанчаар тайлбарлах ёстой.

Тиймээс энэхүү өгүүллийн хүрээнд бичил тандалт хийж, Монголд нийгмийн ухааны чиглэлээр хийгдэж буй хавсарга судалгаануудын онол, арга зүй, шинжлэх ухаанч байдал, судалгаа явуулахдаа мөрддөг наад захын нийтлэг удирдамж (стандарт), арга, аргазүй, аргачлал, судалгааны үе шат, дэс дарааллыг хэрхэн баримталж байгаа байдлыг тодорхойлох замаар хавсарга судалгааны чанарын байдалд үнэлэлт өгөхийг зорьсон болно.

Өгүүллийн хүрээнд хийгдсэн хайгуул судалгааны явцад 2005 оноос хойш Монголд хийгдсэн нийт 37 судалгааны материал цуглуулсан. Мэдээж 37-оос олон байх боломжтой бөгөөд надад олдсон нь энэ юм. Эдгээр 37 судалгаандаа шигшилт хийж, 2010 оноос хойш хийгдсэн, тодорхой хэмжээнд чанарын үнэлгээний шалгуур элементүүдийг агуулсан, харьцангуй “сайн” гэж үнэлэгдэхүйц гэж үзсэн 5-н судалгааг сонгож тандалт шинжилгээ хийлээ. Дашрамд дурьдахад сонгож авсан 5-н судалгааг эрхэлж явуулсан байгууллага, судлаач, судалгааны сэдэв зэргийг нь нууцлахаар шийдсэн. Учир нь үнэлгээ хийж буй аргачлал нь батлагдсан аргачлал биш бөгөөд энэхүү тандалт шинжилгээнд зориулан миний бие анх удаа туршиж буй, өөрөө боловсруулсан зүйл тул алдаа мадаг байхыг үгүйсгэхгүй байна. Тиймээс ёс зүйн асуудал үүсч болзошгүй гэж үзсэн учраас ийнхүү сонгож шинжилгээ хийж буй судалгаануудын талаарх үндсэн мэдээллийг нууцалсан.

Сонгогдсон 5-н судалгааны төлөөлөх чадварыг хангахад анхаарсан.

Үүнд:

1. Нийгмийн шинжлэх ухааны төлөөллийг хангах
2. Судалгаа хийсэн субъектын төлөөллийг хангах
3. Захиалагч буюу санхүүжилтийг харгалзах

Эдгээр 3-н шалгуураар сонгож авсан 5-н судалгааны мэдээллийг хүснэгт 1-ээс үзнэ үү.

Хүснэгт 1: Тандалт судалгаа хийх зорилгоор сонгож авсан 5-н судалгааны төлөөлөх чадвар

	ШУ ба чиглэл	Судлаач ба судалгааны баг	Захиалагч ба санхүүжүүлэгч
Судалгаа 1	Социологи	Эрдэмтэд, багш нарын баг	Төрийн байгууллагын санхүүжилт
Судалгаа 2	Улс төр судлал	Судалгааны чиглэлээр бие даасан байгууллага /төв/	Улс төрийн намын санхүүжилт
Судалгаа 3	Нийгмийн ажил	Холимог багийн судалгаа /эрдэмтэд, судлаач, практик ажилтан гэх мэт	ОУ-ын байгууллагын санхүүжилт
Судалгаа 4	Маркетинг	Бизнесийн байгууллагын маркетингийн нэгж	Байгууллагын өөрийн санхүүжилт
Судалгаа 5	Бодлогын судалгаа	Бие даасан судлаач /хувь хүн/	ОУ-ын байгууллагын санхүүжилт

Үнэлгээг хийхдээ судалгааны үйл явц, үе шат, дэс дараалал бүрд зайлшгүй хийгддэг ажилбаруудыг гол шалгуур болгон сонгож хийсэн. Үүнд:

1. Судалгааны сэдэв томъёолол
2. Сэдвийн судлагдсан байдлын тойм
3. Судалгааны загвар буюу хөтөлбөр
 - 3.1 Судалгааны үндэслэл, баримтад тулгуурласан байдал
 - 3.2 Судалгааны зорилго, зорилт
 - 3.3 Судалгааны асуулт ба таамаглал
 - 3.4 Судалгааны мэдээлэл цуглуулах арга
 - 3.4.1 Судлагдахуунд тохирсон мэдээлэл цуглуулах арга сонгосон эсэх
 - 3.5 Судалгааны түүвэр
 - 3.5.1 Түүврийн хэмжээ
 - 3.5.2 Түүврийн бүтэц
4. Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулалт
 - 4.1 Хэмжилт /шкал байгуулалт/
5. Хээрийн судалгаа, мэдээлэл цуглуулах үйл явц
6. Судалгааны мэдээлэл боловсруулалт
7. Судалгааны тайлан, үр дүн
 - 7.1 Зорилго, зорилт хангагдсан байдал
 - 7.2 Судалгааны асуулт, таамаглал шалгасан байдал
8. Судалгааны үр дүнг амьдралд хэрэгжүүлсэн байдал

Дээрх шалгууруудаар 3-н түвшинд үнэлгээ хийсэн. Үүнд: 1) Бүрэн хангалттай 2 оноо, 2) Хагас хангалттай 1 оноо, 3) Огт хангалтгүй 0 оноо.

Үнэлгээ хийж буй дээрх аргачлал нь хаа нэгтээ батлагдаж, нотлогдсон, олон улсад болон дотоодод хэрэглэгддэг шалгагдсан зүйл биш гэдгийг хэлье. Энэ өгүүлэлдээ зориулан судлаач миний бие санал болгож буй үнэлгээний аргачлал гэдгийг та бүхэн ойлгоорой. Тиймээс алдаатай мадаг байхыг үгүйсгэхгүй ба шүүмжлэлийг нээлттэй хүлээж авна.

Ш. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. Судалгааны сэдэв томъёолол.

Хүснэгт 2: Судалгааны сэдэв томъёололд өгсөн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Сэдэв томъёолол товч, тодорхой ойлгомжтой	2
Судалгаа 2	Сэдэв томъёолол товч, тодорхой ойлгомжтой	2
Судалгаа 3	Сэдэв хамрах хүрээ өргөн, хавсарсан нийлмэл өгүүлбэрээр томъёологдсон	1
Судалгаа 4	Сэдэв томъёолол товч, тодорхой ойлгомжтой	2
Судалгаа 5	Сэдэв томъёолол товч, тодорхой ойлгомжтой	2

2. Сэдвийн судлагдсан байдлын тойм

Хүснэгт 3: Судлагдсан байдлын тоймын үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Дотоодод судлагдсан байдлын тойм хийгдсэн	1
Судалгаа 2	Судлагдсан байдлын тойм хийгдээгүй	0
Судалгаа 3	Дотоодод судлагдсан байдлын тойм хийгдсэн	1
Судалгаа 4	Судлагдсан байдлын тойм хийгдээгүй	0
Судалгаа 5	Судлагдсан байдлын тойм сайн хийгдсэн	2

3. Судалгааны загвар буюу хөтөлбөр

3.1 Судалгааны үндэслэл, баримтад тулгуурласан байдал

Хүснэгт 4: Судалгааны үндэслэлийг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Судалгаа хийх үндэслэлээ тодорхой дэвшүүлсэн	2
Судалгаа 2	Судалгаа хийх үндэслэл бичигдсэн ч баримтад тулгуурлаагүй	1
Судалгаа 3	Судалгаа хийх үндэслэл бичигдсэн ч баримтад тулгуурлаагүй	1
Судалгаа 4	Судалгаа хийх үндэслэл тодорхойгүй	0
Судалгаа 5	Судалгаа хийх үндэслэлээ тодорхой сайн гаргасан	2

3.2 Судалгааны зорилго, зорилт

Хүснэгт 5: Судалгааны зорилго, зорилтыг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Судалгааны зорилгоо томъёолсон байдлыг харвал дүрслэн тодорхойлох /descriptive/ зорилго дэвшүүлсэн байна. Зорилгыг хангах зорилтууд буюу нарийвчлан судлах асуудлуудаа тодорхой дэвшүүлсэн.	2
Судалгаа 2	Дүрслэн тодорхойлох зорилго дэвшүүлсэн. Гэвч зарим зорилтууд нь зорилгоосоо хэт том /зорилгод хамаарахгүй/ асуудлууд байсан	1
Судалгаа 3	Тайлбарлах /explanatory/ зорилго гэж хэлж болохуйц зорилго дэвшүүлсэн. Гэхдээ зорилго тодорхой бус, хэт нурушсан, олон асуудлыг багтаасан. Судалгааны дэс дараалал ажилбаруудыг зорилт болгон дэвшүүлсэн. Жишээ нь анкетаар судалгаа авах, фокус бүлгийн ярилцлага хийх, мэдээлэл боловсруулах гэх мэт.	0
Судалгаа 4	Дүрслэн тодорхойлох маш ойлгомжтой зорилго дэвшүүлсэн. Гэхдээ зорилгыг хангах зорилт буюу нарийвчлан судлах асуудлууд томъёолоогүй.	1
Судалгаа 5	Судалгаагаар бүтээгдсэн мэдлэг, үр дүнд тулгуурлан авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго дэвшүүлсэн байв. Өөрөөр хэлбэл судалгааны зорилго биш байсан. Тухайн судалгаатай холбоогүй жишээгээр тайлбарлавал: “Энэхүү судалгаа нь гэмт хэргийг бууруулах зорилготой” гэсэн байдлаар томъёолсон. Алив судалгаа нь гэмт хэргийг бууруулах талаарх мэдлэг л бүтээхээс бус судалгаа хийгдсэнээр гэмт хэрэг буурахгүй юм. Харин судалгааны үр дүнд тулгуурлан гэмт хэргийг бууруулах нь судалгаанаас шал ондоо үйл ажиллагаа юм.	0

3.3 Судалгааны асуулт ба таамаглал

Хүснэгт 6: Судалгааны асуулт ба таамаглалыг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Судалгааны асуулт байхгүй. Таамаглал дэвшүүлсэн. Бие даасан болон хамаарах хувьсагч бүхий таамаглал дэвшүүлсэн.	2
Судалгаа 2	Судалгааны асуулт, таамаглал дэвшүүлээгүй	0
Судалгаа 3	Судалгааны асуулт, таамаглал дэвшүүлээгүй	0
Судалгаа 4	Судалгааны асуулт, таамаглал дэвшүүлээгүй	0
Судалгаа 5	Судалгааны асуулт байхгүй. Таамаглал дэвшүүлсэн. Гэхдээ хувьсах хэмжигдэхүүнүүд тодохойгүй, дүгнэлт хэлбэрээр хүүрнэн бичсэн.	1

3.4 Судалгааны мэдээлэл цуглуулах арга

3.4.1 Судлагдахуунд тохирсон мэдээлэл цуглуулах арга сонгосон эсэх

Хүснэгт 7: Судалгааны мэдээлэл цуглуулах аргыг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Тоо ба чанарын аргуудыг холимог байдлаар хэрэглэж мэдээлэл цуглуулсан. Үүнд анкет, ганцаарчилсан ярилцлага, баримт бичиг судлах аргуудаар зүйлийнхээ онцлогт тохируулан мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн байна.	2
Судалгаа 2	Тоо ба чанарын аргуудыг холимог байдлаар хэрэглэж мэдээлэл цуглуулсан. Үүнд анкет, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлагын аргуудаар мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн байна. Гэтэл үнэн хэрэгтээ судалгааны зорилго нь дүрслэн тодорхойлох судалгаа байсан ба ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлагаар ямар мэдээлэл цуглуулах нь тодорхой бус байв.	1
Судалгаа 3	Тоо ба чанарын аргуудыг холимог байдлаар хэрэглэж мэдээлэл цуглуулсан. Үүнд анкет, ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлага, баримт бичиг судлах аргуудаар мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн байна.	2
Судалгаа 4	Тоон судалгааны арга буюу анкетаар мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн.	2
Судалгаа 5	Баримт бичиг судлах болон ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулахаар төлөвлөсөн.	2

3.5 Судалгааны түүвэр

3.5.1 Түүврийн хэмжээ

Хүснэгт 8: Судалгааны түүвэрийн хэмжээг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Тоон судалгааны түүврийн хэмжээг эх олонлогийн гишүүдийн тооноос хамааруулан ШУ-ны үндэстэй тогтоосон. Мөн хэдэн хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийхээ урьдчилан төлөвлөсөн.	2
Судалгаа 2	Ямар аргаар, хэдэн хүнээс мэдээлэл цуглуулахаа төлөвлөсөн. Гэхдээ түүвэрлэлтийг ШУ-ны үндэслэл бүхий арга зүйн дагуу хийгээгүй	0

Судалгаа 3	Ямар аргаар, хэдэн хүнээс мэдээлэл цуглуулахаа төлөвлөсөн. Гэхдээ түүвэрлэлтийг ШУ-ны үндэслэл бүхий арга зүйн дагуу хийгээгүй	0
Судалгаа 4	Ямар аргаар, хэдэн хүнээс мэдээлэл цуглуулахаа төлөвлөсөн. Гэхдээ түүвэрлэлтийг ШУ-ны үндэслэл бүхий арга зүйн дагуу хийгээгүй	0
Судалгаа 5	Ямар аргаар, хэдэн хүнээс мэдээлэл цуглуулахаа төлөвлөсөн.	2

3.5.2 Түүврийн бүтэц

Хүснэгт 9: Судалгааны түүвэрийн бүтцийг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Эх олонлогийн бүтцээс хамааруулан квотын аргаар судалгаанд оролцогчдын нас (ахмад, дунд, залуу үе), хүйс, оршин суугаа газар (нийслэл, дүүрэг, аймаг, сум)-ын төлөөлөл ямар хэмжээтэй (бүтэцтэй) байхыг тодорхой заасан.	2
Судалгаа 2	Аль нь ч түүврийн бүтэц буюу төлөөлөх чадвар ямар байхыг урьдчилан тооцоогүй. Нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, оршин суугаа газар болон бусад нийгэм, хүн ам зүйн шинж тэмдгийн хувьд эх олонлогоо төлөөлөхүйц бүтэц бүхий түүвэр олонлог үүсгэх талаар ямар ч төлөвлөлт хийгээгүй.	0
Судалгаа 3		0
Судалгаа 4		0
Судалгаа 5		0

4. Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулалт

4.1 Хэмжилт /шкал байгуулалт/

Хүснэгт 10: Судалгааны хэмжилтийг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Анкет боловсруулахдаа номиналь, ординаль, интервал шкалуудыг маш оновчтой, хэмжилтийн ямар нэг алдаагүй байгуулж чадсан байна.	2
Судалгаа 2	Хэмжилтийн алдаа их. Тухайлбал нэрлэсэн шкалаар хэмжигдсэн асуултанд утгуудын хооронд агуулгын давхцал үүсгэх (агаарын бохирдол, утаа), ординал шкал байгуулахдаа эрэмбийн алдаа (сайн, дунд, муу, маш муу гэх мэт) цөөнгүй гаргасан байв.	0
Судалгаа 3	Хэмжилтийн алдаа их	0
Судалгаа 4	Хэмжилтийн алдаа их	0
Судалгаа 5	Анкетийн судалгаа аваагүй учраас шкал байгуулаагүй. Тиймээс үнэлэх боломжгүй гэж үзээд шууд бүтэн оноо өгсөн.	2

5. Хээрийн судалгаа, мэдээлэл цуглуулах үйл явц

Хүснэгт 11: Судалгааны мэдээлэл цуглуулах үйл явцыг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Хээрийн судалгаа буюу мэдээлэл цуглуулах үйл явцыг хэрхэн зохион байгуулсан талаар товч дурдсан	1
Судалгаа 2	Хээрийн судалгааг хэрхэн зохион байгуулсан нь тодорхой биш	0
Судалгаа 3	Хээрийн судалгаа буюу мэдээлэл цуглуулах үйл явцыг хэрхэн зохион байгуулсан талаар товч дурдсан	1
Судалгаа 4	Хээрийн судалгааг хэрхэн зохион байгуулсан нь тодорхой биш	0
Судалгаа 5	Хээрийн судалгаа буюу мэдээлэл цуглуулах үйл явцыг хэрхэн зохион байгуулсан талаар товч дурдсан	1

6. Судалгааны мэдээлэл боловсруулалт

Хүснэгт 12: Судалгааны мэдээлэл боловсруулалтыг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Тоон судалгааны мэдээллийг SPSS программаар анхдагч түвшинд (давтамж, хувь бодох) боловсруулсан, 2-3 асуултууд хооронд харьцуулалт (crosstabs) хийсэн. Гүнзгийрүүлсэн статистик боловсруулалт (корреляци, регресс)-ийн шинжилгээ хийгээгүй. Чанарын судалгаа буюу ганцаарчилсан ярилцлагын мэдээллийг хэрхэн боловсруулсан нь тодорхойгүй. Гэхдээ тоон судалгааны зарим үр дүнг бататгах, тайлбарлахдаа ганцаарчилсан ярилцлагаас иш татах, кейс байдлаар шигтгээ оруулж тайлангаа бичсэн. Баримт бичиг судлах аргаар цуглуулсан тоо баримт болон зарим мэдээллийг мөн холбогдох хэсэгт нь оруулж тоон судалгааныхаа үр дүнг бататган тайлбарласан байв.	1
Судалгаа 2	Тоон судалгааны мэдээллийг SPSS программаар анхдагч түвшинд (давтамж, хувь бодох) түвшинд боловсруулсан, харьцуулалт хийгээгүй. Статистик боловсруулалт хийгээгүй. Фокус бүлэг, ганцаарчилсан ярилцлагын мэдээллээ хэрхэн боловсруулсан нь тодорхойгүй.	0
Судалгаа 3	Тоон судалгааны мэдээллийг SPSS программаар анхдагч түвшинд (давтамж, хувь бодох) түвшинд боловсруулсан, харьцуулалт хийгээгүй. Статистик боловсруулалт хийгээгүй. Фокус бүлэг, ганцаарчилсан ярилцлагын мэдээллээ хэрхэн боловсруулсан нь тодорхойгүй.	1
Судалгаа 4	Тоон судалгааны мэдээллийг SPSS программаар анхдагч түвшинд (давтамж, хувь бодох) түвшинд боловсруулсан, харьцуулалт хийгээгүй. Статистик боловсруулалт хийгээгүй.	0
Судалгаа 5	Ганцаарчилсан ярилцлагын аргаар цуглуулсан мэдээллүүдээ агуулгаар нь бүлэглэж, нэгтгэн дүгнэсэн. Боловсруулалт хийсэн арга зүйгээ тодорхой нэрлээгүй. Мөн кейсэд тулгуурлан нөхцөл байдал, үр дагаварыг тайлбарлаж дүгнэлт хийсэн байсан.	1

7. Судалгааны тайлан, үр дүн

7.1 Зорилго, зорилт хангагдсан байдал

Сонгон авч шинжилгээ хийсэн судалгаанууд бүгдээрээ тодорхой хэмжээнд мэдлэг бүтээж, анх дэвшүүлсэн зорилго, зорилтоо янз бүрийн түвшинд (харилцан адилгүй) хангасан гэж үзэж байна. Гэхдээ аль ч судалгааны тайланд анх төлөвлөхдөө дэвшүүлж байсан зорилго, зорилтууддаа хэрхэн хүрсэн, эсвэл хүрч чадаагүй талаар системтэй, цэгцтэй, тодорхой өгүүлээгүй байв. Судалгааны анх дэвшүүлсэн зорилго, зорилт ямар түвшинд хангагдсаныг судалгааны тайлан буюу бүлэг, гарчиг, дэд сэдэв, санал зөвлөмж, дүгнэлтэд бичигдсэн агуулгад нь шинжилгээ хийж, дараах байдлаар дүгнэлээ.

Хүснэгт 13: Судалгааны зорилго, зорилт хангагдсан байдлыг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Үнэлгээ
Судалгаа 1	Зорилго, зорилтодоо дэвшүүлсэн асуудлуудаа харьцангуй сайн дүрслэн харуулж чадсан. Сэдвийн дүр зураг, нөхцөл байдал, тоо хэмжээ, хандлага зэргийг тодорхой харуулсаны зэрэгцээ зарим асуудлын учир шалтгааныг ч сайтар тайлбарлаж чадсан. Харьцангуй шинэ мэдлэг бүтээсэн.	2
Судалгаа 2	Анкетийн судалгааны үр дүнг тоочих байдлаар тайлан бичигдсэн. Зөвхөн анкетийн судалгааны асуултанд хариулсан үр дүнгээр судлагдахууны ерөнхий дүр зураг, хандлагыг тодорхойлж дүгнэлт хийсэн нь өрөөсгөл болсон ба зорилго, зорилт бүрэн хангагдсан гэж үзэхэд учир дутагдалтай байв. Ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлагуудын үр дүнг хэрхэн ашигласан нь тодорхойгүй.	1
Судалгаа 3	Анх дэвшүүлсэн зорилго нь хэт ерөнхий төдийгүй дэвшүүлсэн зорилтууд нь шаардлага хангахгүй байсаныг дээр өгүүлсэн билээ. Тиймээс уг судалгааг зорилго, зорилтоо хангаж чадсан эсэхийг үнэлэх боломжгүй байсан. Тайланд маш олон асуудлыг багтаасан байх ба зарим нь сэдвээсээ хазайсан, хэт өргөн хүрээний асуудлууд тайланд бичигдсэн байна.	1
Судалгаа 4	Зорилго тодорхой дэвшүүлсэн ч зорилтууд дэвшүүлээгүй тухай дээр бичсэн билээ. Тодорхой асуудал дээр фокуслагдсан сэдэв, зорилго бүхий судалгаа байсан учраас тайлан дахь үр дүн ч мөн адил зорилготойгоо шууд уялдаатай бичигдсэн. Гэвч судалгааны арга зүй, аргачлал дээр алдаанууд цөөнгүй гаргасан. Тухайлбал хэмжилт нь буруу хийгдсэн, наад захын чанар шаардлагын түвшинд хүрэхгүй анкетаар мэдээлэл цуглуулсан учраас бодит байдалтай нийцэх үр дүнтэй судалгаа болж чадсан эсэх нь эргэлзээтэй.	1
Судалгаа 5	Анх судалгааныхаа зорилгыг дэвшүүлэхдээ алдаа гаргасаныг дээр дурьдсан. Энэ нь найруулгын алдаа байсан нь тайлангаас тодорхой харагдана. Ер нь уг судалгааг зорилгоо тодорхой түвшинд хангасан гэж дүгнэж болно.	1

7.2 Судалгааны асуулт, таамаглалыг шалгасан байдал

Хүснэгт 14: Судалгааны таамаглал шалгагдсан байдлыг үнэлсэн үнэлгээ

	Үнэлгээ ба тайлбар	Оноо
Судалгаа 1	Асуулт байхгүй. Таамаглал дэвшүүлсэн боловч түүнийг хэрхэн шалгасан талаар болон батлагдсан, няцаагдсан талаар ямар ч мэдээлэл тайланд дурьдаагүй.	0
Судалгаа 2	Асуулт, таамаглал дэвшүүлээгүй	0
Судалгаа 3	Асуулт, таамаглал дэвшүүлээгүй	0
Судалгаа 4	Асуулт, таамаглал дэвшүүлээгүй	0
Судалгаа 5	Таамаглалаа буруу томъёолсон. Тайландаа таамаглал батлагдсан гэж дүгнэсэн.	0

8. Судалгааны үр дүнг амьдралд хэрэгжүүлсэн байдал

Судалгааны үр дүнг амьдралд хэрэгжүүлсэн байдал нь хамгийн чухал үзүүлэлт боловч сонгож авсан 5-н судалгааны үр дүнг захиалагч нар хэрхэн үйл ажиллагаандаа ашигласан талаар мэдээлэл олдоогүй, бүрхэг байсан тул энэ шалгуурыг үнэлгээнд оруулаагүй болно.

III. ДҮГНЭЛТ

Эрдэм шинжилгээний өгүүллийн хүрээнд хийсэн бичил судалгааны үр дүнг дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

1. Сонгосон 5-н судалгааг үнэлэхдээ шалгуур тус бүрийг *бүрэн хангалттай 2 оноо, хагас хангалттай 1 оноо, огт хангалтгүй 0 оноогоор* тус тус үнэлсэн билээ. Нийт 13 шалгуураар үнэлсэн ба 100 хувь гүйцэтгэл бүхий судалгаа 26 оноо авсан байх ёстой. Ингээд судалгаа тус бүрийн үнэлгээг нэгтгэж үзье. (Хүснэгт 15) Хүснэгтэн дэхь үнэлгээний нэгтгэлийг харвал хамгийн сайн нь 81%, хамгийн муу нь 23%-ийн гүйцэтгэлтэй гэж үнэлэгдсэн байна. Энэ нь харьцангуй доогуур үнэлгээтэй байгааг харуулж байна.

Хүснэгт 15: Үнэлгээний нэгтгэл

	Авбал зохих оноо	Үнэлгээний нийт оноо	Үнэлгээний хувь
Судалгаа 1	26	21	81%
Судалгаа 2	26	6	23%
Судалгаа 3	26	8	31%
Судалгаа 4	26	6	23%
Судалгаа 5	26	16	61.5%

2. Судалгааны үйл ажиллагааны дэс дараалал, үе шат маш их зөрчигдөж байна. Сонгож авсан 5-н судалгаанаас гадна хайгуул судалгаа хийх үед цуглуулж танилцсан 30 гаруй судалгааны дийлэнх нь мөн ийм байсан. Ер нь нийгмийн судалгааг хэт хялбарчлах, амархан гэж үзэх хандлага нийтлэг байна гэж дүгнэж байна. Хэтрүүлэн хэлбэл ямар нэгэн сэдвийн ерөнхий чиглэл сонгоод, түүнтэй холбоотой хэдэн асуулт хаанаас ч хамаагүй бодож олоод (зохиогоод), түүнийгээ хэнээр ч хамаагүй бөглүүлээд, давтамж хувь бодоод, тоочин тайлагнахыг нийгмийн судалгаа гэж ойлгох хандлага байна.

Сонгож авсан 5 судалгааны тухайд ч судалгааны зарим үе шат болон зайлшгүй хийх ёстой зарим ажилбарыг орхигдуулсан дутагдлууд байна. Тухайлбал шинжилгээ хийсэн 5 судалгааны тухайд авч үзвэл судлагдсан байдлын тойм огт хийгээгүй 2 судалгаа, таамаглал огт дэвшүүлээгүй 3 судалгаа, түүврийн хэмжээг үндэслэлтэй ба үндэслэлгүй тогтоосон ч түүврийн бүтцийг нарийвчлан тогтоогоогүй 4 судалгаа гэх мэт. Судалгааны үе шат бүрд зайлшгүй гүйцэтгэх ажилбарыг хийсэн ч хагас дутуу, чанаргүй, буруу, шинжлэх ухаанч бус хийх нь бас л нийтлэг байна. Үүнд судлагдсан байдлын тойм хийхдээ хангалттай мэдээ материал цуглуулахгүй байх, цугларсан мэдээлэлдээ шинжлэх ухааны аргаар шинжилгээ хийхгүйгээр нэрлэх, тоочих төдий орхих, судалгааны хөтөлбөр буюу дизайныг боловсруулахдаа зарим элементийг орхих, буруу томъёолох, зэрэг асуудал бараг бүх судалгаан дээр ажиглагдаж байна.

3. Тиймээс цаашид судалгааны чанар, стандартын асуудалд анхаарал хандуулах зайлшгүй шаардлага байна гэж үзэж байна. Шаардлага хангахгүй судалгааны үр дүн тайлангууд нь хувь хүн, байгууллага, орон нутаг, улс орны нийгэм эдийн засаг, ирээдүйн хөгжилд маш их хор хөнөөл үзүүлэх нь ойлгомжтой. Түүнчлэн нийгмийн шинжлэх ухаан, түүний бүрэлдэхүүн дэх мэргэжлүүдийн нэр хүндэд ч сөрөг нөлөөтэй. Иргэд олон нийтийн шинжлэх ухаан, судалгаанд итгэх итгэл ч алдарна. Өнөөдөр Монголд нийгмийн судалгааны, тэр дундаа хавсарга судалгааны үр дүн, чанарыг хэмждэг, түүнд үнэлгээ дүгнэлт өгдөг стандарт, дүрэм журам, эрх бүхий байгууллага битгий хэл энэ талаар дуугардаг эрдэмтэн, судлаач, шүүмжлэгч, мэргэжлийн хүн ч бараг алга. Тиймээс чанаргүй судалгаагаар бизнес эрхлэгчээс авахуулаад байгууллага, орон нутаг, төр засаг, улс үндэстний хэмжээнд “судалгаанаас харахад” хэмээн судалгааны нэрээр түрий барьж дутуу дулимаг, хор хөнөөлтэй бодлого шийдвэр гаргагчид цөөнгүй болсон байна.
4. Хөгжингүй орнуудад хавсарга судалгааны чанар, стандартыг хэрхэн хангадаг, хэн, ямар байгууллага, бүтэц механизмаар хяналт тавьдаг талаар судлах, Монголд энэ хэм хэмжээ, соёлыг хэрхэн бий болгох боломжтойг нарийвчлан судлах шаардлагатай гэж үзэж байна. Миний бие цаашид энэ асуудалд анхаарч, цуврал өгүүлэл бичих зорилго тавин ажиллах болно.

НОМ ЗҮЙ

1. *Andrea Bonaccorsi (Ed) “The Evaluation of Research in Social Sciences and Humanities” Springer International Publishing AG 2018.*
2. *Ц.Баатартогтох. “Нийгмийн шинжлэх ухааны судалгааны арга зүй” Удирдлагын академи. УБ 2012*
3. *Коллин Робсон. “Бодит ертөнцийг судлахуй” Монсудар 2006*